



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А1359

Улаанбаатар хот

「Баянгол дүүргийн 66 дугаар цэцэрлэгийн
эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 04 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 12,082,070 (арван хоёр сая наян хоёр мянга дал) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Баянзүрх дүүргийн 66 дугаар цэцэрлэг (Ж.Нарандулам)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 7 нэр төрлийн 1,600,970.00 (нэг сая зургаан зуун мянга есөн зуун дал) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, хасагдаж буй 12 нэр төрлийн 10,481,100.00 (арван сая дөрвөн зуун наян нэгэн мянга нэг зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн харилцааны газарт хүлээлгэн өгөхийг Баянзүрх дүүргийн 66 дугаар цэцэрлэг (Ж.Нарандулам)-т, татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА



В.ОЮУМАА

Нийслэлийн Өмчийн Харилцааны газрын
 даргын 2025 оны 06 дугаар сарын 14-ны
 өдрийн А/139 дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн 66 дугаар цэцэрлэг

| № | Эд хөрөнгийн нэр | Ашигласан жиж | Хэмжээ жиж | Нэгжийн үнэ | Нийт үнэ | Байгуулсан элэгдэл | Үлдэгдэл үнэ | Эвдрэл гэмтэл | ӨБЭ-ийн хурлын дүгнэлт | Байгууллагын үнийн санал | НӨХТ-ийн мэргэжлийн үнийн санал | ҮХХК-ийн хурлын шигээр |
|----|--|------------------|---------------|--------------|--------------|-----------------------|-----------------|------------------|------------------------------|-----------------------------|---------------------------------------|------------------------------|
| 1 | Угаалтын машин хагас автомат /BSB-7кг/ | 11 | 1 | 320,000.00 | 320,000.00 | 320,000.00 | - | Эвдэрсэн | актлах | актлах | татах | татах |
| 2 | Нөүтбүүк samsung /i5 (2016PPR2256)/ | 6 | 1 | 1,800,000.00 | 1,800,000.00 | 1,800,000.00 | - | Эвдэрсэн | актлах | актлах | татах | татах |
| 3 | Будаа агшаагч 18 кг / PSIGROE/ | 6 | 1 | 560,000.00 | 560,000.00 | 560,000.00 | - | Эвдэрсэн | актлах | актлах | татах | татах |
| 4 | Хөлдөөгч /FRESTEC/ | 6 | 1 | 300,000.00 | 300,000.00 | 300,000.00 | - | Эвдэрсэн | актлах | актлах | татах | татах |
| 5 | Цаг бүртгэлийн техөөрөмж | 5 | 1 | 445,000.00 | 445,000.00 | 445,000.00 | - | Эвдэрсэн | актлах | актлах | устах | устах |
| 6 | Гадна камер | 5 | 2 | 215,000.00 | 430,000.00 | 430,000.00 | - | Эвдэрсэн | актлах | актлах | устах | устах |
| 7 | Тоос сорогч / Electrolux 71 DB/ | 5 | 2 | 399,900.00 | 799,800.00 | 799,800.00 | - | Эвдэрсэн | актлах | актлах | татах | татах |
| 8 | Тоос сорогч / Electrolux 74 SW/ | 5 | 1 | 459,900.00 | 459,900.00 | 459,900.00 | - | Эвдэрсэн | актлах | актлах | татах | татах |
| 9 | Индүү/panasonic/ | 5 | 4 | 64,900.00 | 259,600.00 | 259,600.00 | - | Эвдэрсэн | актлах | актлах | устах | устах |
| 10 | Rotenzo 17-кг тай угаалтын машин | 5 | 1 | 469,900.00 | 469,900.00 | 469,900.00 | - | Эвдэрсэн | актлах | актлах | татах | татах |
| 11 | Жингийн тооцоолуур /TCS/ Зөөврийн | 5 | 1 | 58,300.00 | 58,300.00 | 58,300.00 | - | Эвдэрсэн | актлах | актлах | устах | устах |
| 12 | компьютер /Dell intel core i5-826U/ | 4 | 2 | 1,749,500.00 | 3,499,000.00 | 3,499,000.00 | - | Эвдэрсэн | актлах | актлах | татах | татах |

